БАТЛАВ

Аймгийн БТСГ-ын даргыг түр

орлон гүйцэтгэгч Б.Буянтогтох

2022 оны 04 дугаар сарын 25 өдөр

**Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад хийж хяналт шалгалтын удирдамж**

Чойр хот

**Нэг.Хяналт шалгалтын ажлын зорилго**

1.1 Байгууллагын жижүүрүүдийн гүйцэтгэдэг үйл ажиллагаа болон аюулгүй байдал түүний үйл ажиллагаа, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид давтан гаргуулахгүй байх талаар зохих арга хэмжээ авч, усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааг сайжруулах, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахад оршино.

**Хоёр.Хяналт шалгалтын чиглэл, ажлын зохион байгуулалт**

2.1. Хяналт шалгалт нь эрсдэлийн үнэлгээний судалгаар гарсан эрсдэл өндөртэй үйл ажиллагааг хамааруулж үзнэ.

2.1.1. Жижүүрүүдийн ажлын гүйцэтгэл

2.1.2 Ажлын байрны аюулгүй байдал

**Гурав.Хяналт шалгалт явуулах, дүгнэх,тайлагнах**

3.1. Хяналт шалгалтын ажилд ЗААА-ны нийт жижүүрүүд хамрагдах ба шаардлагатай тохиолдолд дээд албан хаагчдыг татан оролцуулж болно.

3.2. Хяналт шалгалт нь байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй, хөнгөн шуурхай, удирдамжид заасан хугацаанд явагдах ба шалгагдагч алба нь шалгагдах болон шалгаж буй ажилтнуудыг ажиллах боломж нөхцлөөр хангаж, шаардлагатай баримт мэдээллийг гаргаж өгнө.

3.3. Хяналт шалгалтыг удирдамжийн хавсралтад заасан үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэн, үр дүнг холбогдох удирдлагад танилцуулж мэдээлнэ.

3.4. Хяналт шалгалт явуулж буй ажилтнууд нь шалгалтын явцад илэрсэн ажлын ахиц, дэвшилттэй шинэлэг байдал, зөрчил дутагдал зэрэг нөхцөл байдлыг нотлох бүхий л боломжтой арга хэлбэрийг сонгож хэрэглэх ба шаардлагатай тохиолдолд бодит байдлыг дүрс бичлэг, гэрэл зураг, цаасан болон цахим байдлаар баталгаажуулна.

**Дөрөв. Ажлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1. Хяналт шалгалтын дүн, илтгэх хуудсыг хяналт шалгалт явуулсан өдрөөс хойш ажлын 10-15 хоногт багтаан хяналт шалгалт явуулсан албанд хүргүүлнэ.

4.2. Ажлын явцад хууль тогтоомж, дүрэм журам, зааврын хэрэгжилтэд зөрчил дутагдал илэрсэн бол хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулах ба хууль тогтоомжийн хэрэгжилтийг ноцтой зөрчсөн бол байгууллагын байцаагчийн үүднээс хуулийн хариуцлага тооцно .

Удирдамж боловсруулсан:

Дотоод хяналт хариуцсан ажилтан Ганпүрэв Н.Ганпүрэв

2022 оны 04 дугаар сарын 23 өдөр

## Шалгуур үзүүлэлт

| д/д | Шалгуур үзүүлэлт | Дүгнэх үзүүлэлт | Үр дүнгийн үнэлгээ | |
|---|---|---|---|---|
| 1. | Аюулгүй ажиллагааны сургалт | Нийт ажилтныг сургалт зохион байгуулдаг. | 1 | 0,5 |
| | | Шинээр ажилд орж байгаа ажилтны сургалтанд хамруулах. | 1 | 1 |
| 2 | Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл | Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг хэрэглүүлж хэвшүүлсэн, түүний тогтмол хянаж байх. | 1 | 1 |
| | | Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг үнэ төлбөргүй олгодог. | 1 | 1 |
| | | Өндөрт ажиллах бүсийн баталгаажуулсан | 1 | 1 |
| 3. | Цахилгаан аюулгүй байдал | Аюулгүй байдлыг сэрэмжлүүлэх, анхааруулах санамж байршуулсан. | 1 | 1 |
| | | Цахилгааны шатны аюулгүй байдал, өрөөнүүдийн залгуур, уртасгагчын аюулгүй байдал. | 1 | 1 |
| 4. | Галын аюулгүй байдал | Галын аюулгүй байдлыг хангах дотоод журамтай, аюулгүй гарцтай батлагдсан зурагтай. | 1 | 1 |
| | | Гал унтраах анхн шатны багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал | 1 | 1 |
| | | Галын аюулаас урьдчилан сэргийлэх санамжуудтай | 1 | 1 |
| | | Ажилтнууд галын хор ашиглаж сурсан. | 1 | 0,5 |
| ҮНЭЛГЭЭ | | | 11 | 10 |
| ХУВЬ | | | 100% | 90% |

Дундаж оноог гаргахдаа авсан нийт оноог дүгнэсэн үзүүлэлтийн тоонд хувааж гаргана.

ДҮГНЭСЭН: Н. Ганнурэв ............ Ганнурэв ............

ТАНИЛЦСАН: Эрдэнэдэлгэр ............ [signature] ............

2022 оны 06 сарын 05 өдөр

**ЗААА-ны жижүүрүүдийн хийж гүйцэтгэдэг ажил болон ажлын байрны аюулгүй байдалд хийсэн хяналт шалгалтын зөвлөмж**

| д/д | Шалгуур үзүүлэлт | Дүгнэх үзүүлэлт | Зөвлөмж |
|---|---|---|---|
| 1 | Жижүүрүүдийн ажлын гүйцэтгэл | Ажлын төлөвлөгөө гаргасан эсэх<br>Хийсэн ажлын тайлан | Ажлын төлөвлөгөө хийдэгүй, сар бүр хийсэн ажлаар ажлаа тайлагнан урамшуулалт цалин авдаг. Төлөвлөгдөөгүй тэмцээн уралдаан гарч ирдэг хэдий ч төлөвлөгөөг сар улирлаар гаргадаг болох. |
| 2 | Ажлын байрны аюулгүй байдал | Каркат төмөр дээр бөмбөг тогтох болон хулдаасан хэвлэл тогтооход хамгаалалтын бүс зүүдэг эсэх | Эрсдэлийн үнэлгээгээр хамгийн өндөр гарсан. Карказ төмөр дээр гарахдаа хөдөлмөр хамгаалалтын зааварчилгаа авдаггүй, хамгаалалтын бүс зүүдэггүй. Цаашдаа карказ төмрөн дээр гарахдаа нягт мэгэддэн зааварчилгаа авах. Хамгаалалтын бүсийг зүүж хэвших. Жижүүрийн дэвтэр дээр тэмдэглэл хөтлөх. |

Зөвлөмж бичсэн: Хяналт шалгалт хариуцсан ажилтан *Ганпүрэв* Н.Ганпүрэв

Шигшүүрийн ажлын аюулгүй
ажиллагаа ажлын гүйцэтгэлд
хийсэн хяналт шалгалт.

2022. 04.28

Байгууллагын бүтэц, аюулгүй ажиллагаа талаар шигшүүрүүд ажлын явцад хяналт шалгалт хийв. Тэжээн уралдаан хэвийн журмаар үргэлжилж байгаа тул тухай бүр аж ахуйн ажлыг хийж гүйцэтгэв. Хулдаасан хэвлэх тогтоход хамгаалалтын бус зүүх эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай

Тэмдэглэл хөтөлсөн.

Н.Ганпүрэв.

БАТЛАВ

Аймгийн БТСГ-ын даргын түр

орлон гүйцэтгэгч Б.Буянтогтох

2022 оны 04 дугаар сарын 25 өдөр

**Биеийн тамир спортын газрын Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамж**

2022 оны 04 дугаар сар 10 Чойр хот

**Нэг.Хяналт шалгалтын ажлын зорилго**

1.1 Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагаа, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид давтан гаргуулахгүй байх талаар зохих арга хэмжээ авч, усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааг сайжруулах, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахад оршино.

**Хоёр.Хяналт шалгалтын чиглэл, ажлын зохион байгуулалт**

2.1. Хяналт шалгалтын ажил нь дараах чиглэлээр явагдах ба УССТ-н 2022 оны үйл ажиллагааг хамруулж үзнэ.

2.1.1. Цэвэрлэгээ, Үйлчилгээ

2.1.2. Хэрэглэл материал, хадгалалт хамгаалалт

2.1.3. Үйлчилгээ, сургалтын билетийг УССТ-өөр үйлчлүүлэгчдийн бүртгэлтэй тулгах

**Гурав.Хяналт шалгалт явуулах, дүгнэх,тайлагнах**

3.1. Хяналт шалгалтын ажилд УССТ-н нийт ажилчид хамрагдах ба шаардлагатай тохиолдолд дээд албан хаагчдыг татан оролцуулж болно.

3.2. Хяналт шалгалт нь байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй, хөнгөн шуурхай, удирдамжид заасан хугацаанд явагдах ба шалгагдагч алба нь шалгагдах болон шалгаж буй ажилтнуудыг ажиллах боломж нөхцлөөр хангаж, шаардлагатай баримт мэдээллийг гаргаж өгнө.

3.3. Хяналт шалгалтыг удирдамжийн хавсралтад заасан үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэн, үр дүнг холбогдох удирдлагад танилцуулж мэдээлнэ.

3.4. Хяналт шалгалт явуулж буй ажилтнууд нь шалгалтын явцад илэрсэн ажлын ахиц, дэвшилттэй шинэлэг байдал, зөрчил дутагдал зэрэг нөхцөл байдлыг нотлох бүхий л боломжтой арга хэлбэрийг сонгож хэрэглэх ба шаардлагатай тохиолдолд бодит байдлыг дүрс бичлэг, гэрэл зураг, цаасан болон цахим байдлаар баталгаажуулна.

**Дөрөв. Ажлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1. Хяналт шалгалтын дүн, илтгэх хуудсыг хяналт шалгалт явуулсан өдрөөс хойш ажлын 10-15 хоногт багтаан хяналт шалгалт явуулсан албанд хүргүүлнэ.
4.2. Ажлын явцад хууль тогтоомж, дүрэм журам, зааврын хэрэгжилтэд зөрчил дутагдал илэрсэн бол хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулах ба хууль тогтоомжийн хэрэгжилтийг ноцтой зөрчсөн бол байгууллагын байцаагчийн үүднээс хуулийн хариуцлага тооцно .

Удирдамж боловсруулсан:

ТШ,ХШҮ, Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан Ганпүрэв Н.Ганпүрэв

2022 оны 04 дугаар сарын 10 өдөр

**Усан спорт сургалтын төвийн сантехник болон цахилгаан, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал, усны ариутгалын байдалд хийсэн хяналт шалгалтын зөвлөмж**

| д/д | Шалгуур үзүүлэлт | Дүгнэх үзүүлэлт | Зөвлөмж |
|---|---|---|---|
| 1 | цэвэрлэгээ үйлчилгээ | Гадаа талбайн цэвэрлэгээ<br>Цэцэрлэгжүүлэлт<br>Шүршүүрийн цэвэрлэгээ | Хальтарч унахаас урьдчилан сэргийлэх хэвлэмэл наалт 7 ширхэг байна.<br>Цэцэрлэгжүүлэлтийг өөрийн ажилчдын хүчийг ашиглан засаж, янзлан тохижуулсан байна.<br>Ажилчид байгууллагын 7 хоног бүрийн хурал дээр байгууллагын даргаас аюулгүйн ажиллагааны зааварчилгааг тогтмол авдаг.<br>Цэвэрлэгээг тухай бүрт хийж хэвшсэн байна. |
| | | Бассейн цэвэрлэгээ/ усны цэвэр байдал/ | Усны үлдэгдэл хлороос шинжилгээ авах багж, мэргэжлийн хими ч байдаггүй. Орон тоо болон зохиулалтын хөдөлмөр хамгаалалтын багаж байхгүй хүсэлт гарган төсөвт суулгах. |
| | | Бүртгэлийн дэвтэр хөтлөлт | Үйлчлүүлэгч бүрийг тухай бүр бүртгэлийн дэвтэрт хөтлөж, тухай бүр арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. |
| | | Улавч өмсүүлсэн байдал | Үйлчлүүлэгч бүгд өөрийн углааштай ирж үйлчүүлэх нь тогтмолжсон. Өөрийн углаашгүй ирсэн тохиолдолд буцаан явуулж дахин ирэхдээ авч ирэхийг сануулдаг. Энэ тал дээр тэмдэглэл хөтөлдөггүй.<br>Жавлан найруулан ариутгал хийхдээ зориулалтын амны хаалт, бээлий хэрэглэдэггүй энгийн цэвэрлэгээний бээлий хэрэглэж байгаан ноцтой аюултай. Тунгагшуулах бодисыг хэмжих зориулалтын сав байхгүй. Бүгдийг орлуулан ажиллаж байна. |
| 2 | хэрэглэл материал, хадгалалт хамгаалалт | Аврагч хантааз ашиглалт, хадгалалт<br>хөвөгч тавцан ашиглалт, хадгалалт<br>хөвөгч цагираг хадгалалт хамгаалат | Аврагч хантааз, хөвөгч, хөвөгч цагираг, аврагч багийн зоорч төмөр ашиглалт хамгаалалтын сайжруулах зорилгоор зориулалтын хатаагч давцан авсан байна.<br>хадгалалт, хамгаалалт зориулалтын дагуу болсон байна. Үйлчлүүлэгч бүрийг тухай бүр бүртгэлийн дэвтэрт хөтлөж хэвшсэн байна. |
| | | аврагч багийн зоорч төмөр | |
| 3 | Үйлчилгээ, сургалтын билетийг УССТ-өөр үйлчлүүлэгчдийн бүртгэлтэй тулгах | Үйлчилгээний билетийг тоо бүртгэлтэй тулгах<br>Сургалтын билетийг бүртгэлтэй тулгах<br>Үйлчилгээний билетийг тоо бүртгэлтэй тулгах | Үйлчлүүлэгч, сургалт бүрийг тухай бүр бүртгэлийн дэвтэрт хөтлөж, билетийн тулгалт хийж нягтай хамтран ажиллаж хэвшэв.<br>Ямар нэгэн зөрчил, дутагдал байхгүй болно. |

Зөвлөмж бичсэн: Хяналт шалгалт хариуцсан ажилтан Ганпүрэв Н.Ганпүрэв

**Шалгуур үзүүлэлт**

| д/д | Шалгуур үзүүлэлт | Дүгнэх үзүүлэлт | Үр дүнгийн үнэлгээ | |
|---|---|---|---|---|
| 1 | УУСТ-ын сантехник, цахилгааны ажиллагааны аюулгүй байдал | Сантехник, цахилгааны үйл ажиллагаа | 10 | 10 |
| | | Эвдрэл гэмтэлийн бүртгэл | 10 | — |
| | | Эвдрэл гэмтэл зассан байдал | 10 | 10 |
| 2 | Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах | Урьдчилан сэргийлэх хэвлэмэл наалт | 10 | 10 |
| | | Үйлчүүлэгчдийг заавал углааштай оруулах | 10 | 10 |
| | | Ажилчдад үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах талаар зааварчилгаа өгдөг бүртгэл | 10 | — |
| 3 | Усны ариутгал | Хлорын найруулан ариутгал хийх үеийн аюулгүй байдал | 10 | 10 |
| | | Тунгагшуулагч бодисыг найруулах үеийн аюулгүй байдал | 10 | 10 |
| | | Усан дахь халдваржуулах, ариутгах химийн бодисны үлдэгдэлийг хянах байдал | 10 | 10 |
| ҮНЭЛГЭЭ | | | 90 | 70 |
| ХУВЬ | | | 100% | 78% |

Дундаж оноог гаргахдаа авсан нийт оноог дүгнэсэн үзүүлэлтийн тоонд хуваaж гаргана.

ДҮГНЭСЭН:

................................... ..............................................

ТАНИЛЦСАН:

С. Эрдэнэбаатар ..............................................

2022 оны 09 сарын 26 өдөр

| Д/д | Шалгуур үзүүлэл | Дүгнэх үзүүлэлт | Үр дүнгийн үнэлгээ /оноо/ | |
|---|---|---|---|---|
| | | | Авбал зохих | Авсан |
| 1 | Цэвэрлэгээ Үйлчилгээ | Гадаа талбайн цэвэрлэгээ | 5 | 5. |
| | | Цэцэрлэгжүүлэлт | 5 | 5. |
| | | Шүршүүрийн цэвэрлэгээ | 5 | 5 |
| | | Бассейны цэвэрлэгээ /усны цэвэр байдал/ | 5 | 5. |
| | | Бүртгэлийн дэвтэр хөтлөлт | 5 | 5 |
| 2 | Хэрэглэл материал, хадгалалт хамгаалалт | Аврагч хантааз ашиглалт, хадгалалт | 4 | 4 |
| | | Хөвөгч тавцан ашиглалт хамгаалалт | 3 | 3. |
| | | Хөвөгч цагираг хадгалалт хамгаалалт | 3 | 2 |
| | | Аврагч багшийн зоорч төмөр | 5 | 5 |
| 3 | Үйлчилгээ, сургалтын билетийг УССТ-өөр үйлчлүүлэгчдийн бүртгэлтэй тулгах | Үйлчилгээний билетийг тоо бүртгэлтэй тулгах | 10 | 10. |
| | | Сургалтын билетийг бүртгэлтэй тулгах | 10 | 10 |
| Үнэлгээ | | Нийт авбал зохих оноо: | 60 | 60 |
| | | Авсан оноо: | | 59. |
| | | Хувь | 100%. | 98%. |

**УССТ-н үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын шалгуур үзүүлэлт**

Дундаж оноог гаргахдаа авсан нийт оноог дүгнэсэн үзүүлэлтийн тоонд хувааж гаргана. Тухайн үзүүлэлтээр хангалтгүй “0” оноо авсныг үзүүлэлтийг тооноос хасахгүй.

ДҮГНЭСЭН:

Н. Ганпүрэв .............................. Ганпүрэв. ..............................

ТАНИЛЦСАН:

С. Очирбаатар .............................. ..............................

2022 оны 04 дугаар сарын 28 өдөр

This image cannot currently be displayed.

This image cannot currently be displayed.

Биеийн тамир спортын газрын даргын
20.....оны ... сарын....өдрийн ....
тоот тушаалын..... хавсралт

# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН СПОРТЫН САЛБАР ХОЛБООД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

## Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү нийтлэг журмын зорилго нь байгууллагын болон спортын салбар холбоодын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн хяналт шалгалтад хамрагдах өмчийн байгууллага /цаашид "байгууллага" гэх/ энэхүү нийтлэг журмыг дагаж мөрдөнө.

1.3. Байгууллага нь энэхүү нийтлэг журам нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-тай байна.

1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах"-ыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1-д заасны дагуу дараахь эрх бүхий этгээд бат ална.

1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас тохиолдолд "Дотоод шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө.

1.6. Байгууллага нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү нийтлэг журам болон Монгол улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр загаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.

1.7. Хуульд өөрөөр заагаагүй бол аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ/мониторинг/ энэхүү нийтлэг журам хамаарахгүй.

## Хоёр.Дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааны зорилго

2.1 Хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийх, эрсдэлийн удирдлагаар хангаж, тухай байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.